

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



Баруун ба Төв Африкийн удирдагчдын төлөөх залбирал

Сенегал улс итгэл үнэмшлийн хувьд харьцангуй чөлөөтэй нийгэм боловч, итгэлээ ил тод илэрхийлэх, олон нийтийн цуглаанд оролцох эрх чөлөө хязгаартай байдаг. TWR Women of Hope Сенегалын баг эмэгтэйчүүдийн сүнслэг хүчийг бэхжүүлэх, нийгэм дунд ахин урам зориг олгох зорилгоор залбирлын уулзалтуудыг тогтмол зохион байгуулдаг. Эдгээр залбирлын цуглаанууд нь бүх насны эмэгтэйчүүд амьдралын бэрхшээл, хүчирхийлэл, ядуурал, ганцаардал дунд сүнслэг болон сэтгэл санааны тайвшрал өгдөг аюулгүй орон зай болдог.

Women of Hope багийн дамжуулж буй Бурханы Үг нь сонсогчдод Есүст итгэн амьдралаа удирдан чиглүүлэхэд туслалж, тэдний зүрхэнд найдвар ба хайр авчирч, амьдралыг нь өөрчилж байна.



카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면 매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

1. Ариун Аав минь, Баруун ба Төв Африкийн ард түмэнд Өөрийгөө илчилж өгөөч. Тэд бүх зүрхээрээ гэмшиж, Таныг мэдэж, дагахыг эрмэлзэх болтугай! (Илчлэл 22:17)

2. Эзэн, Бенинд Христийг дагахыг хүсэж байгаа эмэгтэйчүүдийг шүтээн шүтэхэд албаддаг хүмүүсийн зүрхийг өөрчилж өгөөч. Тэднийг хамгаалаач. (1 Иохан 5:21)

3. Бурхан минь, зүрх сэтгэл, нийгмийг өөрчилдөг Нэгэн Тал юм. Буркина Фасод эмэгтэйчүүдийг хязгаарладаг буруу уламжлал, ёсыг зоригтойгоор эсэргүүцэж өөрчлөх ухаалаг удирдагчдыг босгож өгөөч. (Галат 3:28)

4. Аав аа, Төв Африкийн Бүгд Найрамдах Улсын залуусын зүрх, оюун бодлыг Өөрийн гарт аваач. Тэднийг ёс бус байдал, завхай соёлын донтолтоос чөлөөлөөч. (1 Коринт 6:18)

5. Эзэн, Кот-д'Ивуарын эмэгтэйчүүдэд аюулгүй орон байж өгөөч. Тэднийг гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн дарамт, ялгаварлалаас хамгаалаач. (Дуулал 32:7)

6. Эзэн, Габоны сайн мэдээ хүрээгүй ард түмнүүдийн дунд сэргэлт авчирч. Таны хүчтэй оршихуй Пигмей болон исламын итгэлтэй хүмүүсийн дунд ч гэсэн, тэдний зүрхэнд гэрэлтэх болтугай. (Ефес 1:18)

7. Бурхан минь, Ганад байгаа эмэгтэйчүүдэд санхүүгийн тогтвортой байдал бий болгож, ядуурлын мөчлөгөөс гарахад нь туслах боломж, нөөц, шинэ замуудыг нээж өгөөч. (Филиппой 4:19)

8. Эзэн, Либерид бие болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг айдас, өвдөлт, сэтгэлзүйн шархаас чөлөөлж, эрх чөлөө өгөөч. (Дуулал 34:18)

9. Аав аа, Мали дахь дайн, үймээнээс өртсөн бүх хүнд амар амгалан, эдгэрэл авчир. Зовнисон зүрхийг тайвшруулж, эв нэгдэл, найдварыг сэргээгээч. (Иохан 14:27)

10. Эзэн, Мавританид охидод хохиролтой соёлын уламжлал, эрт гэрлүүлэх явдлаас хамгаалаач. Эдгээр буруу дадлыг бүр мөсөн зогсоож өгөөч. (Дуулал 9:9)

11. Аав аа, Нигерт байгаа эмэгтэйчүүдийг хүчирхийлэл, аюулаас хамгаалж, Өөрийн оршихуйгаар хамгаалалт, амар амгаланг өгөөч. (Дуулал 46:5)

12. Эзэн минь, Нигерид итгэгч гэр бүлүүдийн харилцаанд хямрал ихэсч байна. Эхнэр, нөхрүүд бие биенээ хайрлаж, хүндэтгэхэд туслаач. (Ефес 5:21–28)

13. Эзэн, Баруун Африкийн ирэх сонгууль тайван орж өнгөрөх болтугай. Ард түмэнд шударга, зөв удирдагчдыг сонгох мэргэн ухааныг өгөөч. (2 Шастир 7:14)

14. Аав аа, Бенинд итгэлээ дагасныхаа төлөө гэр бүл, нөхрөөсөө хавчигдаж буй Христэд итгэгч эмэгтэйчүүдэд зориг, нигүүлсэл, хүч өгөөч. (Ром 8:35)



15. Бурхан минь, Төв Африкийн Бүгд Найрамдах Улсад эмэгтэйчүүдэд ядуурлаас гарахад туслах орлого бий болгох бүтээлч санаа, урам зориг өгөөч. (Исаиа 43:19)

16. Эзэн, Кот-д'Ивуарын эмэгтэйчүүдийг эх, эхнэр, нийгмийн идэвхтэй гишүүн хэмээн хэрхэн амьдрахаа ойлгоход сургаж, хүч чадал өгөөч. (Дуулал 32:8)

17. Бурхан минь, Габонд ард түмнийг төөрөгдүүлэх, хуваах гэсэн Сатаны худал үгсийг нам гүм болгооч. Таны чуулган Есүсийн нэрээр ялалт байгуулах болтугай. (Исаиа 54:17)

18. Эзэн, Ганад итгэл найдвараа алдсан эмэгтэйчүүдэд Та тэдэнд итгэл ба хүчийг өгөөч. Тэднийг зоригжуулж, амьдралын бэрхшээлийг даван гарахад туслаач. (Дуулал 31:24)

19. Аав аа, Либерид шашин, эрх мэдлийг ашиглан эмэгтэйчүүдийг хянаж, ичээж, мөлжиж буй хүмүүсийн зүрхийг өөрчлөөч. (Дуулал 51:10)

20. Мэргэн ухааны Бурхан минь, Мали дахь пасторууд, зөвлөхүүдэд Таны ухаан, тэвчээр, хайрыг өгөөч. Тэднийг даруу зөөлөн зүрхтэйгээр удирдан чиглүүлээч. (Иаков 1:5)

21. Эзэн, Нигерт эмэгтэйчүүд болон гэр бүлүүдэд хоол, цэвэр ус, аюулгүй орон байр өгөөч. Таны элбэг хангалт тэдний амьдралд урсан орох болтугай. (Матай 6:11)

22. Эзэн, Нигерийн Эбони муж дахь TWR Women of Hope залбирлын бүлгийг бэхжүүлээч. Тэдний хүрсэн эмэгтэйчүүд Христийг мэдэж, итгэлдээ өсөх болтугай. (Матай 5:16)

23. Аав аа, Бенинд хүчирхийлэл, дарамтад өртөн дуугүй болсон эмэгтэйчүүдийг чөлөөлж, дуу хоолойг нь сэргээгээч. (Иохан 16:33)

24. Эзэн, Төв Африкийн Бүгд Найрамдах Улсын манай багийг хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд найдвар ба эдгэрэл авчрах үйлчлэлд ашиглаач. (Дуулал 82:3)

25. Бурхан минь, Кот-д'Ивуарын хөдөөгийн бүсийн эмэгтэйчүүдэд бие болон сэтгэлийн эдгэрэл авчираач. Ялангуяа жирэмслэлтийн хугацаандаа эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжийг нь нээгээч. (Иеремиа 17:14)

26. Эзэн, Габонд байгаа бэлэвсэн эмэгтэй, өнчин хүүхэд, өвчтэй хүмүүсийг эдгээ. Тэднийг чуулганаар дамжуулан хайрлан халамжлаач. (Иеремиа 30:17)

27. Эзэн, Либерийн удирдагчдад зориг өгч, эмэгтэйчүүдэд хор хөнөөлтэй уламжлал болох эрхтэнг хөндөх, фистула зэрэг үйлдлийг таслан зогсооход нь туслаач. (Ефес 6:10)

28. Өрөвч Аврагч минь, Мали дахь бэлэвсэн эмэгтэй, ганц бие эхчүүд, асран хамгаалагчдад тайвшрал, хангалт өг. Тэд Таныг зүрхэндээ ойр байлгах болтугай. (Матай 5:4)

29. Эзэн, Women of Hope нэвтрүүлэг одоо Нигерийн “Pidgin English” хэлээр цацагдаж байна! Таныг мэдэж, итгэлдээ өсөхөд нь эмэгтэйчүүдийн амьдралыг өөрчилж өгөөч. (Үйлс 19:20)

30. Эзэн, Кот-д'Ивуарын эмэгтэйчүүдийг удирдагчдын байр суурь нийгэмдээ энх тайван, шударга ёс, хөгжил авчрах урам зориг өгөх болтугай. (Мика 6:8)

Монголын төлөө залбирах сэдвүүд -----

1. Монгол улсад гарч байгаа хүн алга болох, хүүхэд хулгайлагдах, бусдын гарт амиа алдах зэрэг гэмт хэргийн асуудлууд бүрэн шийдвэрлэгдэж, эдгэр гэмт хэргийг үйлдэж байгаа хүмүүс буруугаа хүлээн гэмшихийн төлөө
2. Монгол улсын Засгийн газар ард иргэдээ энэрэн хайрлаж, зөв эрх тэгш бодлогыг хэрэгжүүлэн, ядуурлаас гарахын төлөө.
3. Багш ажилчид эдгээр өдрүүдэд 100% ажил хаялт зарлаж байна. Их Эзэн минь Монгол улсын боловсролын системд ирээдүйгээ, хүүхдүүдээ бодсон шинэчлэл хийж, ирээдүйдээ ээлтэй улс болохын төлөө.

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송
최초 입금 후 사무실로 연락주시기 바랍니다.